

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код 13.060.70

<p style="text-align: center;">Хөрсний чанар. Шимэгч хорхой илрүүлэх арга Soil quality. Method of helminthological analysis</p>	MNS 5034 : 2001
---	------------------------

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн зөвлөлийн 2001 оны 04-р сарын 26-ний өдрийн 21 дугаар тогтоолоор батлав.

2001 оны 05-р сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1. Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэ стандартыг хөрсөнд шимэгч хорхойн өндөг илрүүлж, тодорхойлоход хамаарна

2. Норматив ишлэл

Дор дурдсан стандартууд нь энэхүү стандартын бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ стандартыг нийтлэн гаргах үед эдгээр стандартууд нь хүчин төгөлдөр байсан бөгөөд бүх стандартуудыг дахин хянаж, сайжруулдаг.

MNS ISO 78-2 : 2000	Стандартын бичлэг. 2-р хэсэг. Химийн шинжилгээний арга
MNS 1-3 : 2001	Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 3-р хэсэг: Стандартын бүтэц, бичлэг

3. Аргын үндэслэл

Химийн уусмалд хөвж гарч ирсэн биетээс наалдац авч микроскопын тусламжтайгаар шимэгч хорхойн өндгийг илрүүлж тодорхойлно.

4. Урвалж бодис ба материал

“Шинжилгээнд зориулсан цэвэр” ангиллын урвалж, хоёр дахин нэрсэн ус хэрэглэнэ.

- 4.1. Хурилдуур
- 4.2. Ареометр
- 4.3. Хуруу шил
- 4.4. Дусаагуур

MNS 5034 : 2001

- 4.5. Тавиур шил
- 4.6. Бүрхүүл шил
- 4.7. Колбо
- 4.8. Глицериний 50%-ийн уусмал
- 4.9. Натри калийн шүлтийн 3%-ийн уусма
- 4.10. Азот хүчлийн натрийн ханасан уусмал

5. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

- 5.1. Электрон жин, 0.0001г нарийвчлалтай.
- 5.2. Микроскоп

6. ДЭЭЖЛЭЛТ БА ДЭЭЖ

Дээж авахад тохиромжтой гэж үзсэн хэсэгтээ 25 м² газрыг сонгон авч түүний диагналын дагуу хоорондоо ижил зайтай 8 цэгээс тус бүр 10 гр хөрсийг хөрсний 1-3 см /ногооны талбайгаас 10-20 см/ ийн гүнээс, даршилсан хог бол 1-2 м-ийн гүнээс халбага, хүрэээр авч таглаатай саванд буюу гялгар уутанд хийнэ.

7. ШИНЖИЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

25 гр хөрсийг 250 мл багтаамжтай колбонд хийж дээр нь 3% -ийн натри, калийн шүлтийг 1:1 харьцаатайгаар хийж шилэн савхаар сайтар хутган 20-30 минут тунгаана. Тунгаасан шингэнээ хурилдуурын хуруу шилэнд юүлж 5 минут эргүүлээд тунадасны дээрхи шингэнийг асгаж, тунасан шороог 2-5 удаа цэвэр усаар зайлж асгана.

Хэдэн удаа зайлах нь хөрсний байдлаас шалтгаалж элсэрхэг хөрсийг 1-2 удаа, шавар ба хар шороон хөрсийг 3-5 удаа зайлж зайлсан ус нь тунгалаг болно. Зайлсан хөрсөн дээрээ 45 мл азот хүчлийн натрийн ханасан уусмал хийж савхаар сайн хутгаад дахин хурилдуурт эргүүлнэ.

/Ханасан уусмал бэлтгэхийн тулд 1 кг азот хүчлийн натри ба гипосульфат натри дээр 1 л ус нэмж уусмалд өрөм тогттол нь халаагаад хөргөж ареометрээр хэмжихэд уусмалын нягт 1.38-1.40-өөс багагүй байх ёстой./

Дараа нь шинжилгээтэй хуруу шилнүүдийг тэгш сууринд суурилуулж хуруу шилийг дүүртэл нь азот хүчлийн натри хийж, тавиур шилээр хагас бүтээгээд завсраар нь дусаагуураар ханасан уусмалыг бүтээсэн тавиур шилэнд хүртэл нэмж тавиур шилээр хуруу шилийг бүтэн бүтээж 20-25 минут тавина.

Хуруу шил дэх усны өнгөрөөс гадагш асгарахгүй байх ёстой. 20-25 минутын дараа хуруу шилийг бүтээсэн тавиур шилийг эргүүлэн авч шинжлэх талбайд 50% глицерин 1-2 дуслыг дусааж бүтээгч шилээр бүтээн бичил харуурт харж шинжилнэ.

Тавиур шилэн дээр наалдсан хорхойн өндгийг илрүүлэхийн тулд 80 дахин / об. 8 ок 10/, өндөгний хөгжлийн үе шатыг тодорхойлоход 400 дахин / об 60 x 0.65 x ок 10/ тус тус томруулна.

8 Үр дүнг илэрхийлэх

Бичил харуурт харж шимэгч хорхойн өндөг байгаа эсэхийг тогтооно. Өндөг илэрсэн тохиолдолд “Шимэгч хорхойн өндгийг таних бичиг” –ийн тусламжтайгаар тодорхойлно.

Хавсралт А (Мэдээлэл)

Ном зүй

- 1 Шимэгч хорхойн өндгийг таних бичиг

ТӨГСӨВ.